

Олон Улсын
Хөдөлмөрийн
Товчоо

БҮХ НИЙТИЙГ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН СУУРЬ ТҮВШИНД ХАМРУУЛАХЫГ ДЭМЖЬЕ!

АЖИЛ ХЭРЭГ БОЛГОХ ЦАГ БОЛЖЭЭ



*“Өнөө үед нийгмийн хамгааллыг хүний
эрх, эдийн засгийн зөв бодлого гэдгээр
нь хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй.”*

Гай Райдер, ОУХБ-ын Ерөнхий захирал



Шинэ зөвшилцөл

Ядуурал буурахгүй, тэгш бүс байдал нэмэгдсээр байгаа энэ үед дэлхий нийтээр нийгмийн хамгааллыг өргөжүүлж, хүртээмжтэй өсөлт, хөгжлийг дэмжих шаардлагатайг хүлээн зөвшөөрөөд байна.

ОУХБ-ын гишүүн орнуудын Засгийн газар, ажилчдын болон ажил олгогчдын байгууллагууд хамтран нийгмийн хамгааллын хүрээнд Их 20 болон НҮБ-аас дэмжигдсэн шинэ хандлагыг нэвтрүүлж, Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай 202 дугаар зөвлөмжийг батлан гаргав.

ОУХБ-ын энэхүү зөвлөмж нь Нийгмийн хамгааллын суурь түвшнийг бүрдүүлэх, нийгмийн хамгааллыг өргөжүүлэхэд баримтлах стратегийн талаар тодорхой удирдамж чиглэл өгч, амьдралд бодитой хэрэгжүүлэх шийдвэртэй арга хэмжээ авахыг уриалсан юм. Энэ нь нийгмийн дэвшил, эдийн засгийн сэргэлт, шударга даяаршлын төлөө тэгш эрхийг хангаж, нийгмийн шударга ёсыг бэхжүүлэхэд нийгмийн хамгаалал чухал үүрэгтэйг дахин баталгаажуулсан юм.



“Би бусдаас өглөг хандив горьдож суух хэрэггүй болсон”

Кабо-Верде улсын иргэн 81 настай Луиза Маркус ач зээ нартайгаа загасчны тосгонд амьдардаг. Луиза олон жилийн турш гэр бүлийнхээ тусламж дэмжлэгээр амьдарч байна. “Амьдрал хэцүү байна. Тэнгис ихэнхдээ тодорхойгүй, хүүхдүүд маань чадах чинээгээрээ тусалдаг ч өөрсдөө гэр бүлтэй хүмүүс шүү дээ.”

2011 оноос Луиза сард 50 орчим ам.долларын нийгмийн тэтгэвэр авдаг болсон. Ийм тэтгэвэр хүмүүсийн, тэр дундаа хөдөө орон нутагт амьдардаг эмэгтэйчүүдийн амьжиргаанд ихээхэн өөрчлөлт авчирдаг. Олон Кабо-Верде эмэгтэйчүүд насаараа ажилласан хэдий ч өндөр насны тэтгэвэргүй хоцордог байна. “Хэмжээ нь их биш ч миний амьдралыг өөрчилж чадсан. Одоо би тэтгэврээрээ наад захын хэрэгцээт зүйлээ авдаг, бусдаас өглөг хандив горьдож суух хэрэггүй болсон.”

Тус улс 2007 оноос нийгмийн тэтгэвэр олгож эхэлсэн бөгөөд 2009 он гэхэд уг тэтгэвэрт нийт өндөр настай эмэгтэйчүүдийн 74 хувь нь хамрагджээ. Татвараар санхүүждэг уг тэтгэврйин нийт зардал ДНБ-ий 0.4 хувийг л эзэлж байна.

Нийгмийн хамгааллын суурь түвшин гэж юү вэ?

Нийгмийн хамгааллын суурь түвшин нь бүх хүнийг орлогын суурь баталгаагаар хангаж, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах зорилготой наад зах нь нийгмийн хамгааллын дөрвөн үндсэн баталгаанаас бүрдэх үндэснийхээ түвшинд тодорхойлсон багц юм.

Нийгмийн хамгааллын суурь түвшнийг нийгмийн яриа хэлэлцүүлгээр тодорхойлж, хүмүүс зохистой амьдрах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй. Түүнчлэн суурь түвшнийг бүрдүүлж буй баталгаануудыг хуулиар тогтоож, хэрэгжилтийг нь тогтмол хянаж үнэлдэг байх шаардлагатай.


Нийгмийн хамгааллын суурь түвшний тухай 2012 оны 202 дугаар зөвлөмж нь хоёр үндсэн зорилгыг дэмждэг:

- 1) Нийгмийн хамгааллын цогц тогтолцооны цөм нь нийгмийн хамгааллын суурь түвшин байхаар бүрдүүлэх.
- 2) Нийгмийн хамгааллын (доод хэм хэмжээний) тухай 102 дугаар конвенц болон ОУХБ-ын нийгмийн хамгааллын бусад хэм хэмжээг удирдлага болгон хамгааллын түвшинг байнга дээшлүүлэх.

Нийгмийн хамгааллын суурь түвшний бүрэлдэхүүн хэсгүүд:

Нийгмийн хамгааллын доод түвшин бидэнд яагаад хэрэгтэй вэ?

Нийгмийн хамгаалал бол тогтвортой хөгжлийг хангах чухал бодлого бөгөөд ...



	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд бүх нийтийг хамруулах		39%	Дэлхийн хэмжээнд эмнэлгийн тусламж, үйлчилгээний тогтолцоо буюу эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй хүн амын эзлэх хувь
			41%	Эрүүл мэндийн нийт зардалд өрхүүд өөрсдөө төлж буй эрүүл мэндийн шүүд төлбөрийн эзлэх дундаж хувь
	Дэлхийн хэмжээнд эрүүл мэндийн салбарт 10.3 сая ажилтан дутагдалтай байна.			
	Хүүхдийн нийгмийн хамгаалал		50%	Дэлхийн хэмжээнд ядуурлын түвшнээс доогуур амьдарч буй хүүхдийн эзлэх хувь
	0.4%	Засгийн газрууд хүүхэд, гэр бүлийн тэтгэмж, тусламжид хуваарилж буй хөрөнгийн ДНБ-д эзлэх дундаж хувь. Ийм хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.		
	Ихэнх тохиолдолд урьдчилан сэргийлэх боломжтой өвчний улмаас өдөр бүр 18,000 хүүхэд амь насаа алдаж байна.			
	Хөдөлмөрийн насны хүн амын нийгмийн хамгаалал		12%	Дэлхийн хэмжээнд ажилгүйдлийн тэтгэмж авч буй ажилгүйчүүдийн эзлэх хувь
			28%	Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авч буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь
			39%	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамрагдсан ажилтны эзлэх хувь
	Тэтгэвэр, ахмад настны асрамж, халамж		49%	Тэтгэвэргүй байгаа тэтгэврийн насны хүмүүсийн эзлэх хувь
			41%	Тэтгэврийн даатгалд хамрагдаж шимтгэл төлж буй (15-аас дээш насны) ажилтнуудын эзлэх хувь
	300 сая ахмад настан зохистой түвшинд амьдрах орлогын баталгаагүй байна.			

Нийгмийн хамгааллын суурь түвшний хамрах хүрээг тасралтгүй өргөжүүлж бүх нийтийг хамруулах

Нийгмийн хамгааллын суурь түвшин: эдийн засгийн зөв бодлого

Нийгмийн хамгааллын суурь түвшний хамрах хүрээг тасралтгүй өргөжүүлснээр хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж, хүмүүсийн зохистой ажил олох чадавхийг дээшлүүлэн нийт эрэлтийг тогтворжуулж, дотоодын эдийн засгийг дэмжих замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад хувь нэмрээ оруулдаг.




ОУХБ улс орнуудыг нийгмийн хамгааллын суурь түвшнээ бүрдүүлэхийг дэмждэг

ОУХБ олон улсын хэмжээний тусгайлсан хөтөлбөр, мэргэжил-арга зүйн туслалцаа үзүүлэх бүтцээрээ дамжуулан:

- Нийгмийн хамгааллын тогтолцооны дизайныг төлөвлөх, зардлыг тооцох, хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлдэг
- Нийгмийн хамгааллыг өргөжүүлэх асуудлаар үндэсний түвшинд олон талт хэлэлцүүлэг зөвшилцлийг дэмждэг
- Нийгмийн хамгааллын суурь түвшнийг бүрдүүлж, нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хамрах хүрээг бодитой өргөжүүлэхийг зөвлөдөг
- Нийгмийн хамгааллын (доод хэм хэмжээний) тухай 102 дугаар конвенц болон түүнээс өндөр стандарт тогтоосон бусад конвенцид нэгдэн орохыг идэвхтэй дэмждэг
- Мэдлэг бий болгож түгээдэг.

ОУХБ нь НҮБ-ын улс орнууд дахь хамтарсан баг болон ОУХБ, Дэлхийн банк хамтран ахалдаг Нийгмийн хамгааллын асуудлаарх хамтын ажиллагааны зөвлөл зэрэг байгууллага хоорондын бүтцүүдээр дамжуулан бусад түншүүдтэй хамтран ажиллаж байна.

ОУХБ-аас сүүлийн жилүүдэд нийгмийн хамгааллын чиглэлээр 135 гаруй оронд техникийн туслалцаа үзүүлсэн байна.



Цаашдын алхам?

Одоо ажил хэрэг болгох цаг болжээ!

Дэлхийн 184 улс нийгмийн хамгааллын суурь түвшнээ бүрдүүлж, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх стратегиа үндэснийхээ хэмжээнд хэлэлцэн боловсруулах амлалтыг аваад байна. Үүний тулд дараах асуудлуудаар тохиролцоонд хүрсэн юм:

- Үндэснийхээ тэргүүлэх чиглэлүүдтэй нийцүүлэн зорилгоо тодорхойлох
- Нийгмийн хамгааллын хүрээнд оршиж буй дутагдал, саадыг тодорхойлох
- Тохирох хөтөлбөрүүдийг харилцан уялдаатайгаар боловсруулах
- Нийгмийн хамгааллыг хөдөлмөрийн зах зээлийн бодлоготой холбох
- Өртөг зардлыг тооцож, шаардагдах нөөцийг тодорхойлон дэвшилтэт зорилтууд дэвшүүлэх
- Нийгмийн хамгааллын таллаарх ойлголтыг дээшлүүлэх.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөжүүлэх чиглэлд олон улс орон мэдэгдэхүйц ахиц гаргаж чадсан юм. Нийгмийн хамгааллын суурь түвшнийг бүрдүүлж хангах боломжтой гэдгийг эдгээр орны туршлага харуулж байна.

“Дэлхийн эдийн засгийн сэргэлт тодорхойгүй, эрэлт буурч байгаа үед нийгмийн хамгааллын суурь түвшнийг бүрдүүлэх нь эдийн засгийг тогтворжуулах, хүртээмжтэй өсөлтийг дэмжих, улс төрийн тогтвортой байдлыг хангах боломжийг олгоно. Нийгмийн хамгааллын суурь түвшин нь улс орнуудад ядуурлыг бууруулах, тэгш бус байдлыг хазаарлах, өөрчлөлтөд дасан зохицож, даван туулах чадварыг сайжруулах, хүнийг тогтвортой хөгжүүлэх үндэс суурийг бүрдүүлэхэд нь туслах чухал хэрэгсэл юм.”

НҮБХХ-ийн захирагч Хелен Кларк,
ОУХБ-ын Ерөнхий захирал Гай
Райдер нарын хамтарсан уриалга

www.social-protection.org

 Нийгмийн хамгааллын платформ

 @soc_protection